



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.26 № 31-1/55
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002209



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.19 № ХЭГ/1709

танай _____-ны № _____-г

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт 217 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265005657

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“14.ХЭЛЭЛЦСЭН нь: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Ашигт малтмалын тухай хууль нь геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, салбарт оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулсан байдаг бөгөөд түүнийг бусад хуультай нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага хэдийнээ үүсээд байна.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг, 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 11 бүлэг, 59 зүйлийн хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ нь хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, улмаар хөрөнгө оруулалтыг бууруулах эрсдэлд хөтөлж байна. Ерөнхийд нь авч үзвэл анх батлагдсан хуулийн үзэл баримтлал эрс өөрчлөгдсөн гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт зэрэг нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүсээд байгааг харуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д зааснаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байгааг тодорхойлж байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.1-д “...ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авахаар заасан бөгөөд уг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт болон өргөдлөөр олгох үйл ажиллагааг цахимжуулж, хайгуулын ажилд зарцуулах хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэс баялгийн нөөцийг арвижуулж, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж хүрэх үр дүнг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д зааснаар “Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээрт үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2-т “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ” гэж заасан.

Эдгээр нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсын эдийн засаг нь бүхэлдээ уул уурхайгаас хамааралтай бөгөөд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ашиглах бодлого нь уул уурхайг дагасан эдийн засгийн бусад салбарыг дэмжих замаар улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой заасан.

Иймээс ч хязгаарлагдмал нөөцийг хариуцлагатайгаар, үр дүнтэйгээр ашиглахад хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Зарим улс орон өөрийн үндэсний аюулгүй байдал болон үйлдвэржилт, олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг “чухал” бүлэгт хамруулан зарлаж тухайн төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд тусгайлан бодлого гарган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд чухал ашигт малтмалын нэр төрлийг тодорхойлж, түүнтэй холбоотой асуудлыг улсын хөгжлийн бодлогод тусгайлан тусгаж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны горимтой байх нөхцлүүдийг хуулиар зохицуулах шаардлага тулгамдаж байна.

Гарал үүсэлгүй хүдрийг худалдан авч хууль бус олборлолтыг өөгшүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил, далд байдлаар хяналтгүй ашиглах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх зэрэг олон сөрөг үр дагаварыг арилгах үүднээс тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг эрх зүйн зохицуулалттай болгох, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Бүх шатны нутгийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх, үүрэг уялдаагүй, давхардалтай, эсхүл тодорхойгүйгээс салбарт оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны эс үйлдэхүй түгээмэл гарах болсны дээр зохион байгуулалттай эсэргүүцлийн ажиллагаа газар авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг зогсоох, энэ нь цаашлаад улс орон нутгийн төсвийн орлогыг тасалдуулах хүртэл сөрөг үр нөлөөг үзүүлж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа нь тэгш шударга, нээлттэй байх зарчмыг хангаж байгаа хэдий ч зарлагдаж буй талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэрэг тохиолдлын эзлэх хувь 40-46 хувьтай байгаагаас сонгон шалгаруулалт зарлаж буй талбайнууд хэтийн төлөвгүй буюу хөрөнгө оруулагчдын сонирхож буй талбай зарлагдахгүй байгааг илтгэж байна.

Иймээс хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааны зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мөн бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, хоршоог ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч этгээд байхаар, тухайн жилийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлдэг байхаар зохицуулалтыг тусгах шаардлага байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь технологийн хувьд ялган авах боломжгүй болон төлбөр төлдөг хорт хольцод тооцогддог дагалдах элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж байгаа уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн хувьд хүндрэл үүсгэж байгаа бөгөөд үүнийг олон улсын жишгийг харгалзан боловсронгуй болгох шаардлагатай.

Эдгээр нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага болно.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана:

-Чухал ашигт малтмалыг тодорхойлж түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар;

-Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг зэрэг баяжуулах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаа;

-Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн геологийн судалгааны ажлыг хувийн хэвшлийн хөрөнгөөр, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, мөн тухайн судалгааны ажлын үр дүнг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцаа;

-Нутгийн захиргааны байгууллагатай харьцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой зохицуулалт;

-Засгийн газар, төрийн захиргааны байгууллага, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийн талаар;

-Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн баталгаа, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах асуудлын талаар.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хувийн өмчийн эрхийг зөрчихгүйгээр, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой болж, бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа эрчимжиж, Монгол Улсын газрын хэвлийн баялгийн нөөц нэмэгдэж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Зарим төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах хувийг оновчтой тогтоох зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хамарсан эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг бий болгоно.

Тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэгдүүлэх, баяжуулах үйлдвэр нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулснаар хариуцлагатай уул уурхайн тогтолцоо улам бэхжинэ. Ингэснээр салбарын талаарх олон нийтийн ойлголт, итгэл нэмэгдэж, эсэргүүцэл багасна.

Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүйд тооцох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн

энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсруулна.

---o0o---

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Товч танилцуулга

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрт онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээр үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн иргэд, салбарын үйл ажиллагаанд оролцогчдын хүсэлт бусад улс, орнуудын ашигт малтмалын эрх зүйн орчин зэрэг нөхцлийг харгалзан үзэж, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд хайгуулын тусгай зөвшөөрлийг олон төрлөөр олгох, ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа, түүний зарчим, чухал ашигт малтмал, нөхөн сэргээлт, хаалт болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, хуваарилалтын асуудлуудыг тусгалаа.

Монгол Улсын уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж, салбарын үйл ажиллагаа эрчимжихийн хирээр түүнийг даган бий болж байгаа шинэ тутам харилцааг 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахад хүндрэлтэй болж байгаа тул дараах агуулгын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх;
- Чухал ашигт малтмалын талаарх бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх;
- Ашигт малтмалын баяжуулах үйл ажиллагааны зохицуулалт;
- Геологи, уул уурхайн салбар дахь орон нутгийн оролцоог оновчтой болгох;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Орон нутгийн нэгдсэн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх.

Одоогоор дэлхийн улс орнууд 30-50 төрлийн эрдэс, элементийг чухал ашигт малтмалын жагсаалтдаа тодорхойлсон бөгөөд Монгол Улсад хийгдсэн геологи, хайгуулын ажлын үр дүнд эдгээр элементийн хуримтлал бүхий цэгүүд нэлээдгүй байгаа нь тогтоогдсон байдаг. Иймд манай улс “Чухал ашигт малтмалын бодлого”-оо тодорхойлж, олон улсад танилцуулан хэрэгжүүлснээр энэ төрлийн ашигт малтмалын судалгааг гүнзгийрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, гадаадын хөрөнгө оруулалт татах, технологийн дэвшлийг нутагшуулах, бэлдэц бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын дэд бүтэц, хүний нөөцийн чадавхаа бэхжүүлэх боломж нээгдэнэ.

Хуулийн төсөлд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад хамруулахаар зорьсон. Ялангуяа, гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмалыг хяналтгүйгээр худалдан авч хууль бус олборлолтыг өөгшүүлэх, татвараас зайлсхийх зэрэг олон сөрөг үр дагавар үүсгэж байгаа гажуудлыг арилгана.

Орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хөрөнгийг уул уурхайн олборлолт хийгдэж байгаа аймаг, суманд түлхүү хуваарилах бодлогыг баримталж, Төсвийн тухай хуульд заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төвлөрсөн орлогыг орон нутагт дахин хуваарилдаг хувь, хэмжээг нэмэгдүүлэх болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн хөгжлийн санд хуваарилдаг хувь хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хэт өндрөөр тогтоосон нь Монгол Улсад шинээр зэсийн ордыг ашиглалтад оруулах нөхцөлийг бууруулж байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-30 хувь, баяжмалд 0-15 хувь, бүтээгдэхүүнд 0-5 хувь байхаар заасан. Харин хуулийн төсөлд “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-15 хувь, баяжмалд 0-5 хувь, бүтээгдэхүүнд 0-2.5 хувиар ногдуулахаар өөрчлөн тусгалаа.

Ашигт малтмалын тухайн хуулийн шинэчилсэн найруулга 2006 онд батлагдан 2007 онд хэрэгжиж эхлэх үед хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 4111 (2008 онд) байсан бол 870 (2023 онд) болон буурч, үүнтэй холбоотойгоор оргил үедээ 335 тэрбум төгрөгт хүрч байсан гадаадын хөрөнгө оруулалт өнгөрсөн онд 104 тэрбум төгрөг болж, 3 дахин буурсан байна. Мөн 1997 оноос хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн үе болон өнөөдөр хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн харилцан хамаарлыг судлахад 200 хайгуулын тусгай зөвшөөрөл тутмын 1 нь олборлолтод шилжиж байна. Иймд хайгуулын ажлыг эрчимжүүлснээр ашигт малтмалын шинэ орд газрыг нээх боломжийг нэмэгдүүлж, улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх юм.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа нь тэгш, шударга, нээлттэй байх зарчмыг хангаж байгаа хэдий ч зарлагдаж байгаа зарим талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд зөвхөн нэг санал ирэх зэрэг тохиолдлын эзлэх хувь 40-46 хувьд хүрч байна. Энэ нь сонгон шалгаруулалт зарлаж байгаа талбайд хэтийн төлөв бүхий талбай бага, хөрөнгө оруулагчдын сонирхол татахуйц талбай зарлагдахгүй байгааг илтгэж байна. Иймд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг хувийн хэвшлийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талаар төсөлд тусгасан.

Баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Мөн уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн баталгаа, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах асуудлыг хуулийн төсөлд тусгасан.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг оролцогч талууд болох иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, 21 аймагт хэлэлцүүлж, давхардсан тоогоор 1448 ирснээс 50 гаруй хувийн саналыг хуулийн төсөлд тусгасан.

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсрууллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсруулсан.

---ooOoo---

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Дэлгэрэнгүй танилцуулга

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасан.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж хуульчилсан.

Үндсэн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тус тус баталсан. Мөн 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрт онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээр үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Засгийн газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч холбогдох эрх зүйн зохицуулалтуудын хийдэл болон өөр хоорондын уялдаагүй байдлаас үйл ажиллагаа зогсонги байдалд орох, биржийн арилжаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн орлогыг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байгаа нь Үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл үүсгэх эрсдэлтэй байна.

Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг тодорхой болгоно” гэж тусгасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтуудын биелэлтийг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар Үндэсний баялгийн санг арвижуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Нэг. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох хүрээнд ашигт малтмалын суурь харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагатай байгаа бөгөөд уул уурхайн салбарт дараах асуудлууд тулгамдаж байна.

1. Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль нь уурхайн амьдралын мөчлөгтэй холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулаагүй, зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлөн уялдаагүй;

2. Ашигт малтмалын тухай хууль нь “тусгай зөвшөөрөл”-тэй холбоотой харилцааг голчлон зохицуулахад чиглэгдсэн бөгөөд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нөхөн сэргээлт, хаалттай холбоотой харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан;

3. Хуулийн зарим заалт нь хэт ерөнхий зохицуулалттай буюу тухайлсан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй, аливаа зохицуулалтад тавигдах шаардлага тодорхойгүй;

4. Байгаль орчны хууль тогтоомж, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хууль, бусад холбогдох журмаар уул уурхайн салбарт холбогдох асуудлыг тодорхой хүрээнд зохицуулж байгаа боловч тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалтгүй;

5. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо ихтэй, улс төрийн нөлөөлөлд өртөмтгий зэрэг болно.

Хоёр. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтын тухай

Хуулийн төсөлд геологи, уул уурхайн салбарын тогтолцоо, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа, түүний зарчим, тусгай зөвшөөрлийн зохицуулалт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн оролцоог тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан.

Түүнчлэн, баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл олгох, баяжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулах үйл ажиллагаа эрхлэх, хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавих шаардлагатай холбоотой зохицуулалтууд бүхий бүлгийг нэмэхээр хуулийн төсөлд тусгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Ашигт малтмалын тухай хуульд дараах асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар нарийвчлан тусгалаа:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх;

- Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа;
- Ашигт малтмалын баяжуулах үйл ажиллагааны зохицуулалт;
- Геологи, уул уурхайн салбар дахь орон нутгийн оролцоог оновчтой болгох;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Орон нутгийн нэгдсэн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх.

2.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар.

Хайгуулын үйл ажиллагаа нь улс орныг урт хугацаанд эрдэс баялгийн найдвартай нөөцөөр хангах, уул уурхайн салбарын үйл ажиллагааг тогтвортой байлгах, ашигт малтмалын сан хөмрөгийг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг тасралтгүй, найдвартай хангах замаар улс орны эдийн засгийн суурь үндсийг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийг тэтгэж өгөх үүрэгтэй.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2006 онд батлагдан 2007 онд хэрэгжиж эхлэх үед хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 4111 (2008 онд) байсан бол 870 (2023 онд) болон буурч, гадаадын хөрөнгө оруулалт оргил үедээ 335 тэрбум төгрөгт хүрч байсан бол өнгөрсөн онд 104 тэрбум төгрөг болж, 3 дахин буурсан байна. Мөн 1997 оноос хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн үе болон өнөөдөр хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн харилцан хамаарлыг судлахад 200 хайгуулын тусгай зөвшөөрөл тутмын 1 нь олборлолтод шилжиж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа нь тэгш, шударга, нээлттэй байх зарчмыг хангаж байгаа хэдий ч зарлагдаж байгаа зарим талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэрэг тохиолдол 40-46 хувьд хүрч байгаа нь сонгон шалгаруулалт зарлаж байгаа талбайд хэтийн төлөв бүхий талбай бага буюу хөрөнгө оруулагчдын сонирхсон талбай зарлагдахгүй байгааг илтгэж байна. Энэ нь 2018 онд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болох талбайг баталснаас хойш тухайн талбайд ашигт малтмалын хэтийн төлөв бүхий сонголт үлдээгүйтэй мөн холбоотой.

Иймд Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг хувийн хэвшлийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талаар төсөлд тусгасан. Мөн Засгийн газраас гадаадын улс орнуудтай хамтран чухал ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар хуулийн төсөлд тусгасан.

2.2.Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар

Цэвэр эрчим хүч үйлдвэрлэлийн хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр чухал ашигт малтмал (Critical mineral)-ын ханган нийлүүлэлт эрсдэлтэй тулгарч байгааг улс орнууд анхааралдаа авч, бодлого, стратегиа шинэчлэх, хэрэгжилтийн арга хэрэгслүүдээ өргөжүүлэх, үндэсний болон үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн аюулгүй байдлыг баталгаажуулах арга хэмжээг эрчимтэй эрэлхийлсээр байна.

Үүний улмаас чухал ашигт малтмалын эцсийн хэрэглэгч улс орнууд төдийгүй түүний ханган нийлүүлэлтийн глобал сүлжээнд оролцогч, олборлогч, боловсруулагч улс орнууд ч чухал ашигт малтмалын талаарх бодлого, стратегиа тодорхойлсоор байна. “Чухал ашигт малтмал” хэмээх ойлголт нь тухайн улс орны батлан

хамгаалах, эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц ашигт малтмалын талаарх ойлголтоос нэгэнт хальж, цэвэр эрчим хүчний салбар дахь аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар, уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлах, хүлэмжийн хийг бууруулах улс төрийн амлалт, ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээнд онцгой байр суурь эзэлж, шинэ ажлын байр, хөгжлийн шинэ боломжуудыг бий болгох, улмаар олон улсын хамтын ажиллагааны хүрээнд өргөжсөөр байна.

Одоогоор дэлхийн улс орнууд 30-50 элементийг чухал ашигт малтмалын жагсаалтдаа тодорхойлсон бөгөөд Монгол Улсад хийгдсэн геологи, хайгуулын ажлын үр дүнд эдгээр элементийн хуримтлал бүхий цэгүүд нэлээдгүй байгаа нь тогтоогдсон байдаг.

2.3. Ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагааны зохицуулалтыг шинээр тусгах талаар.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн “ашигт малтмал ашиглах” гэдэг тодорхойлолтоос жишээ татахад “хүдэр олборлох, олборлосон хүдрээ баяжуулж боловсруулан бүтээгдэхүүн гаргах, түүнийгээ зах зээлд борлуулах” хүртэл үйл ажиллагаа нь ашиглалтын гэх нэг тусгай зөвшөөрлөөр дамжин хэрэгжих зохицуулалттай. Нэг талаас эдгээр үйл ажиллагаанууд нь нэг этгээдийн цогц үйл ажиллагаагаар хэрэгжиж болохоор харагдавч нөгөө талаар бүгд тус, тусдаа бие даасан үйл ажиллагаа бөгөөд тус бүрд нь өөр, өөр субъект хэрэгжүүлэх боломжтой. Олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд тэр бүр баяжуулах үйлдвэрлэл эрхэлдэггүйгээс өөрөө олборлолт явуулдаггүй зөвхөн олборлосон ашигт малтмалыг олборлогчдоос худалдан авч ашигт агуулгыг нь нэмэгдүүлэх, баяжуулах, хагас боловсруулах үйл ажиллагаа явуулдаг компаниуд олноор бий болж байна.

Түүнчлэн хатуу болон шингэн хэлбэрийн хаягдлын аж ахуй, ядуу агуулгатай хүдрийн овоолго зэргийг ашиглах эрх зүйн зохицуулалт оновчгүйгээс ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны үүрэг хариуцлага болон техник, технологийн шаардлагуудаас зайлсхийх зорилгоор тэдгээрийг дахин ашиглалгүй бусдад худалдах, түрээслэх, өөр аж ахуйн нэгжийн нэр дээр баяжуулалт хийх замаар татвар, хураамж төлөхгүй байх арга замыг эрэлхийлэх тохиолдлууд гарсаар байгаа тул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн үүсмэл ордыг өөрөө ашиглах хөшүүргийн механизмыг бүрдүүлж, “ашигт малтмал баяжуулах” тусгай зөвшөөрлийн тухай зохицуулалтыг хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах тухай зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгасан.

2.4. Геологи, уул уурхайн салбар дахь орон нутгийн харилцаа, иргэдийн оролцоог төсөлд тусгах талаар.

Геологи, уул уурхайн салбарын талаарх бүх шатны нутгийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх үүрэг давхардалтай, эсхүл тодорхойгүйгээс, мөн хууль, эрх зүйн олон актад харилцан адилгүй зохицуулалттайгаас үүдэн салбарт оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх, төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны эс үйлдэхүй түгээмэл гарах болсны дээр эсэргүүцлийн зохион байгуулалттай үйл ажиллагаа газар авч,

тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг зогсоох, цаашлаад улс, орон нутгийн төсвийн орлогыг тасалдуулах хүртэл сөрөг нөлөөг үзүүлэх болсон.

Иймд салбарын харилцаан дахь нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо, чиг үүрэгтэй холбоотой дараах өөрчлөлтийг тусгасан:

- Салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгт оролцох, санал, зөвлөмж өгөх;
- Хайгуул, ашиглалт, баяжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй байх, тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааныхаа талаар тогтмол мэдээлж тайлагнах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах, эс үйлдэхүй гаргахыг хуулиар хориглож, саад учруулсан болон эс үйлдэхүй гаргасан албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах зэрэг болно.

2.5.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар.

Ашигт малтмалын тухай хуульд заасан нөөц ашигласны төлбөрийг Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан “төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялаг ашигласны төлбөр” гэж заасантай уялдуулах өөрчлөлтийг тусгасан.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүрдүүлж байгаа хувь хэмжээнээс нь хамаарч тухайн орон нутагт нь илүү хуваарилах зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан.

Тухайлбал, орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг үр дүнд үндэслэн, уул уурхайн олборлолт хийгдэж байгаа аймаг, сумдад түлхүү хуваарилах бодлогыг баримталж, Төсвийн тухай хуулийн 59.7-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс төвлөрсөн орлогыг орон нутагт дахин хуваарилдаг хувь, хэмжээг нэмэгдүүлэх болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн хөгжлийн санд хуваарилдаг хувь хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хэт өндрөөр тогтоосон нь Монгол Улсад шинээр зэсийн ордыг ашиглалтад оруулах нөхцөлийг бууруулж байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-30 хувь, баяжмалд 0-15 хувь, бүтээгдэхүүнд 0-5 хувь байхаар заасан. Харин хуулийн төсөлд “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-15 хувь, баяжмалд 0-5 хувь, бүтээгдэхүүнд 0-2.5 хувиар ногдуулахаар өөрчлөн тусгалаа.

Үүнтэй холбоотойгоор зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг оновчтой тогтоохын зэрэгцээ төсвийн орлогыг бууруулахгүй байх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг төрийн өмчит хуулийн этгээд дангаар эрхлэх тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 47.5-д заасан "зэс"-ийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тодорхойгүй хугацаагаар тогтоож, улсын төсөвт төвлөрүүлэх талаар хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн баталгаа, хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах талаар хуулийн төсөлд тусгасан.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг оролцогч талууд болох иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, 21 аймагт хэлэлцүүлж, давхардсан тоогоор 1448 ирснээс 50 гаруй хувийн саналыг хуулийн төсөлд тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж байгаа үр дүн

Манай улс "Чухал ашигт малтмалын бодлого"-оо тодорхойлж, олон улсад танилцуулан хэрэгжүүлснээр энэ төрлийн ашигт малтмалын судалгааг гүнзгийрүүлэх, шинээр орд газруудыг нээн илрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улс дахь түншүүдээс хөрөнгө оруулалт татах, технологийн дэвшлийг нутагшуулах, бэлдэц бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын дэд бүтэц, хүний нөөцийн чадавхаа бэхжүүлэх боломж нээгдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэр нь ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад бүрэн хамруулахаар зорьсон. Ингэснээр, тусгай зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаарч ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар Ашигт малтмалын тухай хуульд 2019 онд оруулсан өөрчлөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт цогц байдлаар бүрдэнэ. Ялангуяа, гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмалыг хяналтгүйгээр худалдан авч хууль бус олборлолтыг өөгшүүлэх, татвараас зайлсхийхээс гадна баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил, далд байдлаар хяналтгүй ашиглах, хаягдлын аж ахуйн горим алдагдах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх, хаалтын болон явцын мониторинг хийгдэхгүй байх зэрэг олон сөрөг үр дагавар үүсгэж байгаа гажуудлыг арилгана.

Төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний геологийн алба болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын эрх үүргийг тодорхой болгож, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн суурь судалгаа, эрлийн ажлыг хувийн хөрөнгөөр гэрээгээр гүйцэтгүүлэн, гэрээний үндсэн дээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүргийг тодорхой болгох, нутгийн захиргааны байгууллагатай харьцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон мэдээ, тайлан хугацаандаа үнэн зөв тайлагнах үр дүн гарна.

Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх зохицуулалтыг бий болгосноор ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй баяжуулах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрчимжиж, ажлын байрны тоо, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний гарц нэмэгдэнэ. Ингэснээр “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан “нүүрс-хими, кокс химийн цогцолбор, гангийн цогцолбор” зэрэг төслүүд хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилах хувь хэмжээг нэмэгдүүлснээр орон нутагт орох орлого нэмэгдэх боломж бүрдэнэ.

Хайгуулын ажлыг эрчимжүүлснээр ашигт малтмалын шинэ орд газрыг нээх боломжийг өсгөх ба цаашлаад улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх юм.

Дөрөв. Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсрууллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсруулсан.

---ooOoo---

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН ХУУЛИУДЫН ТАНИЛЦУУЛГА

1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай:

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасан “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хэт өндрөөр тогтоож өгсөн нь Монгол Улсад шинээр зэсийн ордыг ашиглалтад оруулах нөхцөлийг бууруулж байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-30 хувь, баяжмалд 0-15 хувь, бүтээгдэхүүнд 0-5 хувь байхаар заасан. Харин хуулийн төсөлд “зэс”-ийн ашигт малтмалын боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ нь зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч хүдэрт 0-15 хувь, баяжмалд 0-5 хувь, бүтээгдэхүүнд 0-2.5 хувиар ногдуулахаар өөрчлөн тусгасан.

Монгол Улсад зэсийн салбарт “Оюу толгой” ХХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ үйл ажиллагаа явуулж байна. “Оюу толгой” ХХК тогтворжуулалтын гэрээгээр зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 5 хувиар ногдуулж байгаа бол “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь 15 хувиар ногдуулж байгаа нь хуулийн дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө бүрэн ногдуулан төлж байгаа хариуцлагатай уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарлаж, үүнээс үүдэлтэйгээр татварын тэгш, шударга байдал алдагдах сөрөг үр дагавар дагуулж байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь нийт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 25-30 орчим хувийг бүрдүүлдэг. Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн-Овоо зэс, молибдений ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар 4 жилийн хугацаатайгаар ногдуулж, 2029 оноос бусад ашигт малтмалын адил тооцохоор хуулийн төсөлд тусгасан.

Ашигт малтмал, газрын тосны газраас гаргасан судалгаанд 2030 оноос зэсийн салбарт 2028-2029 онд 6 төсөл, 2030-2031 онд 7 төсөл, 2032 оноос хойш 5 төсөл хэрэгжихээр байгаа нь Эрдэнэт үйлдвэрийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нөхөх боломжтой гэж үзсэн.

Үүнтэй холбоотойгоор зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг оновчтой тогтоохын зэрэгцээ төсвийн орлогыг бууруулахгүй байх зорилгоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг төрийн өмчит хуулийн этгээд дангаар эрхлэх тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 47.5-д заасан “зэс”-ийн зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшнээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тодорхой хугацаанд тогтоож улсын төсөвт төлүүлж болох боломжийг бүрдүүлэх

талаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

2.Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албыг байгуулсан.

Улсын хэмжээнд, тэр тусмаа Үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор бүс нутгийн геологийн судалгааны ажлуудыг өргөн хүрээтэй хийх, нийгэм, эдийн засгийн төлөвлөлттэй холбоотойгоор ашигт малтмалын зүй тогтлын судалгааг хийж улсын ашигт малтмалын нөөцийг бүрдүүлэх шаардлагатай. Томоохон орд газруудыг илрүүлж, уул уурхайн төслүүддээ тулгуурлаад бүс нутгийн болон улсын хэмжээний нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд Үндэсний геологийн алба дэмжлэг үзүүлэх юм.

Монгол Улсын газар нутгийн геологийн тогтцыг судлах шаардлагатай бөгөөд хүрээлэн буй орчин, суурин газрын төлөвлөлтийг хаана, ямар газар хийх нь илүү ач холбогдолтой, оновчтойг геологийн тогтоц талаас нь нарийвчлан судлах ёстой. Инженер геологи талаасаа суурь мэдээллүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, нарийвчилсан боловсруулж, улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор хийх боломжтой болсон.

Энэ хүрээнд Газрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн “Улсын геологийн сан” гэсэн байсныг “Үндэсний геологийн алба” гэж өөрчлөхөөр тусгасан.

3.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай:

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаах авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.9-д Хүнсний давс олборлож, дотооддоо боловсруулахтай холбоотой зохицуулалт бүхий хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасан.

Хүнсний давс нь аж үйлдвэрийн салбарын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнд ордог хэдий ч давсны дотоодын олборлолт тасралтгүй буурч илүү хямд өртөг бүхий импортын бүтээгдэхүүн нэмэгдэх болсон олон шалтгааны гол нэг нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой юм.

Манай Улсын хувьд 200 гаруй давсны орд байдгаас хүнсний давсны нөөц бүхий уламжлагдаж ирсэн 20 гаруй ордтой бөгөөд Увс аймгийн Давст сумын “Шүдэн уул” ордоос бусад давсны ордууд нь бүгд нуурын давсны ордууд байна.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг Усны тухай хуулийн 22.3-т заасны дагуу усны сан бүхий газрын эргээс 200 метр тогтоох” өөрчлөлтийг оруулсан.

Гэвч нуураас олборлох давс нь 200 метрээс дотогш буюу зарим үед нуураас ч олборлох шаардлага үүсдэг. Иймд усны сан бүхий хамгаалалтын бүсийг 200 метрээр хатуу тогтоосноор нуураас давс олборлоход хүндрэл үүссэн.

Иймд хүнсний давсны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “ашигт малтмал” гэсний дараа “болон нуурын давсны” гэж нэмэхээр тусгасан.

4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнийг дагаж өөрчлөлт орох хуулийн төслүүдэд дараах зөвшөөрлүүдийг шинээр бий болгохоор тусгасан.

Зөвшөөрлийн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр, 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлээр “баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”, “маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” дэмжигдсэн.

Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхойгүй, зөвхөн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журмын хүрээнд төрийн захиргааны байгууллага улсын комисс, уурхай, үйлдвэрийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, тайланг хүлээн авч ажиллаж байна.

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нь гарал үүсэл нь тодорхойгүй түүхий эд баяжуулан борлуулж байгаа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахад хүндрэл учруулж байгаа төдийгүй энэ асуудлаар шүүхийн маргаанууд нэлээдгүй үүссэн.

Иймд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр нэмж тусгасан.

Маркшейдерийн ажил нь ордын бүтэц, газрын хэвлий дэх ашигт малтмалын биетийн хэлбэр, хэмжээ, тэдгээрт ашиг тустай, хортой бүрэлдэхүүн хэсгүүдийн байршлыг судлах, үндсэн чулуулгийн шинж чанар, ажлын орон зайн зохион байгуулалт, уулын ажилтай холбоотой чулуулаг ба газрын гадаргуугийн хэв гажилтын үйл явц, хайгуулын ажлаар илрүүлсэн биет, нөөцийг бүрэн олборлож байгаа эсэх, ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг уурхайн маркшейдерийн ажлаар тодорхойлдог ба гүний байгууламж барих, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатыг төлөвлөж, хяналт тавьж, ажлыг зохион байгуулж, үйл явцыг стандартын дагуу зохицуулдаг мөн карьерын хажуу, хаягдал чулуулгийн овоолгын чулуулгийн хөдөлгөөнд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд чулуулгийн шилжилт хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг цогц үйл ажиллагаа тул мэргэжлийн инженерингийн баг гүйцэтгэдэг олон улсын жишгийн дагуу тухайн зөвшөөрлийг бий болгох хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Зөвшөөрлийн тухай хуульд “Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”-ийг олгох зохицуулалтыг тусгаснаар тухайн зөвшөөрлийг авах хүсэлтэй аж ахуйн нэгжүүд нь уул уурхайн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн

дагуу уулын ажлыг төлөвлөж, гүйцэтгэж байгаа эсэхийг хэмжилтээр тогтоож, цаг хугацаа, хөрөнгө оруулалтын алдагдал, олон хүний амь нас хохирохоос сэргийлэх болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломж бүрдэнэ.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн дагуу орон нутгаас санал авч, нэгэнт олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагаанд тухайн орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс эсэргүүцэх явдал буурахгүй улам даамжирсаар байна.

Уул уурхайн үйл ажиллагаа гэдэг нь эрэл, хайгуул, бэлтгэл, олборлолт, баяжуулалт, нөхөн сэргээлт, хаалт, мониторинг зэргийг багтаасан цогц үйл ажиллагаа юм. Эдгээр үе шат бүхэнд техник, технологийн, эдийн засгийн, инженерчлэлийн нарийвчилсан тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлдэг. Гэтэл хайгуулын шатанд хүртэл орон нутгийн зүгээс эсэргүүцэх явдал гарсаар байгаа бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болоод байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 64¹ дүгээр “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглох” зүйлийг нэмж тусгасан. Тус зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно” гэж, “Геологи, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаанд хууль бусаар халдах, тоног төхөөрөмжийг эвдэх, тээвэрлэлт, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулах, уурхайн гарцыг хаах, цахилгаан, усан хангамжийг зориудаар таслахыг хориглоно” гэж тус тус тусгасан.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 64¹ дүгээр зүйлийг нэмсэнтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 10.27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах зөрчилд санкц нэмж тусгасан. Тус санкцтай холбогдуулан их хэмжээний хохирол гэдгийг Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх заалтыг ойлгохоор тусгалаа.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах зөрчлийг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч харьяаллын дагуу хянан шийдвэрлэхээр зохицууллаа.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн”, “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ”, стратегийн орд газруудын өгөөжийн дийлэнх хэсэг Монголын ард түмэнд буюу ирээдүй болон одоо амьдарч байгаа иргэдэд тэгш олгоно гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь, ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын тогтоосон хувь хэмжээ зэргээс бүрддэг.

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн үйл ажиллагааг Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 2013 оны шинэчилсэн найруулгаар хуульчилсан бөгөөд ОНХС-ийн үйл ажиллагаа нь Төсвийн тухай хуулиас гадна Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоол (ОНХНС болон ОНХС-ийн орлогын шилжүүлэг тооцох аргачлал) зэрэг хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хууль болон төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд албан ёсоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд улсын төсвийн орлогоос, тэр дундаа уул уурхайн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон уул уурхайтай холбоотой орлогоос ихээхэн хэмжээгээр бүрдэж, сум, аймгийн түвшинд иргэдийн оролцоотойгоор тодорхойлсон хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой.

ОНХС-ийн санхүүжилт нь уул уурхайн салбарын орлогоос ихээхэн хамаарч жил бүр харилцан адилгүй хуваарилагдаж иржээ. Тухайлбал, Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн мэдээллээс харахад, тус сангийн үйл ажиллагааны эхэн үе буюу 2013–2014 онд жилдээ 187.5–195.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол 2015–2018 онд уул уурхайн түүхий эдийн үнэ буурч, эдийн засгийн өсөлт удааширсан үед жилдээ 53.0–120.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Түүнээс хойш санхүүжилтийн дүн сэргэсэн боловч 2020–2022 оны Ковид-19 цар тахлын улмаас өсөлт хязгаарлагдмал, тус сангийн үйл ажиллагаа эхэлж байсан үетэй ойролцоо түвшинд хадгалагдаж байсан. Харин 2023–2024 онд уул уурхайн экспорт идэвхэжсэн жилүүдэд тус сангийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж 370-484 тэрбум төгрөгт хүрчээ.

Уул уурхайн салбарын үр өгөөжийг нийт иргэдэд хүртээж байгаа нэг хэлбэр нь тус салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн татварын тодорхой хэсгийг ОНХС-аар дамжуулан орон нутгийн шинжтэй хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж буй явдал юм. 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн энэхүү бодлогын хэрэгжилтээс дүгнэхэд, ОНХС-ийн төсвийн хуваарилалтыг уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагддаг аймаг, сумдад бүрдүүлсэн татварын орлогыг бусад орон нутагт, ялангуяа хүн ам ихтэй, газар нутаг томтой аймаг хотуудад илүү зарцуулж иржээ.

Гэвч энэхүү бүсүүдийн тэнцвэрт хөгжлийг хангах чиглэлтэй бодлого нь төсвийг хэт олон хувааснаар үр ашиггүй хуваарилалтад хүргэх сул тал ажиглагдаж байна. Жишээлбэл, Сангийн яам, Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллээс үзэхэд¹, тус сан 2024 онд 339.3 тэрбум төгрөг зарцуулж 7529 төслийг аймаг нийслэлийн бүх сум, дүүрэгт хэрэгжүүлжээ. Гэхдээ эдгээр төслүүд орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хэр бодитой үр нөлөө үзүүлж байгаа талаар судалгаа дүгнэлт хомс байна.

¹ <https://onhs.mof.gov.mn/>

Мөн уул уурхай нь улсын төсвийн орлогын гол эх үүсвэр байж ирсэн боловч, ОНХС-ийн бүс нутгийн хуваарилалт нь уул уурхайн үйл ажиллагааны эрчим, байгаль орчин, нийгмийн нөлөөлөлтэй бүрэн уялдаагүй, үүний улмаас уул уурхайн үйл ажиллагаа явагдаж сөрөг нөлөөлөлд голчлон өртдөг орон нутгууд улсын төсвийн энэхүү хуваарилалтаас бага хүртэж байна гэсэн шүүмжлэл гарах болсон. Үүнээс шалтгаалаад уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй өрнөдөг аймаг сумдад бүрдүүлсэн татвартай нь харьцуулахад бага төсөв хуваарилагдаж эдгээр орон нутаг дахь уул уурхайн үйл ажиллагааны “нийгмийн зөвшөөрөл” суларч болзошгүй юм.

ОНХНС-ийн орлогын 90 хувь орчим нь АМНАТ-ийн орлогоос бүрдэж байна. АМНАТ нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдийн борлуулалтын орлогод ногддог бөгөөд жилдээ нийт сумын гуравны нэг орчим нь энэхүү АМНАТ-ийн орлого бүрдэхэд хувь нэмэр оруулдаг. Төсвийн тухай хуульд 2021 онд оруулсан өөрчлөлтөөр нийт АМНАТ-ийн орлогоос ОНХНС-д хуваарилах хэмжээ 5 хувь байсныг 10 хувь болгон нэмэгдүүлсэн.

Харин ГНАТ-ийн ОНХНС-ийн орлогод эзлэх хувь харьцангуй бага бөгөөд газрын тосны олборлолт хийгдэж буй Дорнод, Дорноговь аймгийн цөөн хэдэн сумаас тус төлбөрийн орлого бүрддэг. ОНХНС-д тус татварын орлогын 30 хувийг төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуульд заасан. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого нь хамрах талбайн хэмжээнээс хамаарах ба харьцангуй олон аймаг, сумын төсөвт төвлөрдөг боловч үнийн дүнгийн хувьд дээрх төлбөрүүдтэй харьцуулахад бага. Төсвийн тухай хуульд зааснаар тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувийг тухайн аймгийн ОНХС-д хуваарилна.

НӨАТ-ын хувьд, 2021 оноос өмнөх Төсвийн тухай хуульд үүнийг импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний НӨАТ-ын орлогын 5 хувь гэж заасан байсан бол 2021 оны нэмэлт өөрчлөлтөөр энэ заалтыг цуцалж, ОНХНС-ийн орлого улсын төсвөөс зөвхөн дээр дурдсан 3 эх үүсвэрээс санхүүжих болсон.

Жил бүр улсын төсвийг батлахдаа ОНХНС-ийн нийт дүнг дээрх татвар, төлбөрүүдийн урьдчилсан орлогод үндэслэн тогтоож, улмаар тэндээс аймаг, нийслэлийн ОНХС-д шилжүүлэг олгодог. Ингэхдээ Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу ОНХС-ийн хөрөнгийг дараах шалгуураар тус бүр 25 хувийн жинд харгалзуулан хуваарилж байсан. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс. Үүнийг дэд бүтцийн хангамж, хүрээлэн байгаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн байдал, хөгжлийн нөөц, давуу тал, хөдөө аж ахуй зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцно. Энэ шалгуур нь улсын хэмжээнд тэнцвэртэй хөгжлийг дэмжихэд чиглэсэн гол шалгуур бөгөөд хөгжлийн индекс багатай орон нутагт илүү хөрөнгө хуваарилах зарчмыг баримтална.
- Үндэсний статистикийн хорооноос зарласан хүн амын тоо. Хүн ам ихтэй орон нутагт хөрөнгө илүү хуваарилах зарчим баримтална.
- Хүн амын нягтрал, нийслэлээс алслагдсан зай. Хүн амын нягтрал багатай, илүү алслагдсан орон нутагт илүү хөрөнгө хуваарилах зарчмыг баримтална.
- Татварын идэвх санаачилгын индекс. Тухайн орон нутгийн татварын бааз буюу татвар төлөгчдийн татварт хамрагдсан байдал, орон нутгийн татварын төлөвлөгөөний биелэлт зэргийг харгалзан татварын идэвх санаачилга сайтай орон нутагт илүү хөрөнгө хуваарилна.

Эдгээр шалгуураас татварын идэвх санаачилгатай холбоотой сүүлийн шалгуурыг 2021 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хассан бөгөөд үлдсэн 3 итгэлцүүрт харгалзах жин тус бүр 33 хувь болсон. Хассан заалтын оронд 2023 онд уул уурхайн татварын орлого бүрдүүлэхэд гүйцэтгэж байгаа үүргийг харгалзсан дараах заалтыг нэмсэн. Үүнд: ОНХНС-ийн АМНАТ-өөс бүрдсэн орлогын 10 хувийг тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр, 20 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймагт бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж, Газрын тосны нөөц ашигласны төлбөрөөс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр тус тус хуваарилахыг заасан.

Дээрх аргачлалаар аймгуудад хөрөнгө хуваарилсны дараа аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас сум, дүүргүүдийн ОНХС-д хуваарилалт хийдэг. Төсвийн тухай хуулийн 59.2-т аймаг, нийслэл нь ОНХС-ийн төсвийнхөө 60 хувийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахаар заасан. Гэхдээ тус хуульд сумуудад хуваарилахдаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал гэсэн 3 үзүүлэлтийг тэнцүү харгалзан хуваарилахыг заасан байсан бол 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ гэсэн шалгуурыг нэмж, хүн амын нягтрал гэсэн шалгуурыг хасахаар заасан.

Төсвийн тухай хуулийн дээрх өөрчлөлтүүдээс үзэхэд, АМНАТ-өөс голлон бүрдэх ОНХНС-ийн орлогыг аймаг, сумдад хуваарилахдаа урьд нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байгаа орон нутгийн онцлогийг төдийлөн харгалзан үздэггүй байсан бол 2023 оноос хойш энэ байдал эрс өөрчлөгдөж, уул уурхай идэвхтэй явагдаж буй аймаг, сумдад хуваарилагдах АМНАТ-ийн дүн өссөн байна.

Энэ нь манай улсын хувьд орон нутгийн хөгжлийн сангийн тэнцвэртэй хуваарилалтын загвараас уул уурхайн үйл ажиллагааны идэвхийг дэмжих буюу уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн загварт шилжиж байгааг илтгэж байна. Гэвч энэ шинэ хуваарилалт уул уурхай бүхий аймаг, сумдын улсын төсөвт оруулж буй хувь нэмэртэй харьцуулахад бага хэвээр байгаа гэсэн санал шүүмжийг орон нутгийн удирдлагууд хэвлэлээр илэрхийлдэг. Учир нь нийт улсын төсвийн орлогоос уул уурхайн үйл ажиллагааны идэвх багатай аймаг сумдад үзүүлдэг орон нутгийн төсвийн дэмжлэг хэвээр байгаа. Гэтэл уул уурхайн орлогоос бүрдэх ОНХНС-аас аймгуудад хуваарилахдаа уул уурхайтай эсэх итгэлцүүрт бага жин өгч, харин хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, нийгмийн үйлчилгээний хэрэгцээ зэргийг илүүтэй харгалзсан хэвээр байна. Энэ нь 2023 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, уул уурхай бүхий аймаг сумдад төсвийн хөрөнгө оруулалтыг ахиу чиглүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд хангалтгүй байгаа аж.

Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж боловсруулсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтын "... 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10" гэснийг "ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 15" гэж, 59.7 дахь хэсгийг "Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 15 хувийг тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд тэнцүү хэмжээгээр, 30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж, мөн хуулийн 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймаг, улсын зэрэглэлтэй хотод тэнцүү хэмжээгээр тус тус

хуваарилна.” гэж, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах АМНАТ-ийн орлогын итгэлцүүрт “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын хэмжээ”, “ашигт малтмал болон газрын тосны хайгуулын талбайн хэмжээ” гэж тус тус тусгасан.

7.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт өөрчлөлт орох хүртэлх хугацаанд геологийн судалгааны ажил хийгдэж байсан. Геологийн судалгаа ажлыг зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр газрын хэвлийг хөндөхгүй, шинжлэн ухааны чиглэлээр газрын гадаргууд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр явуулдаг. Дархан цаазат газарт хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах зохицуулалт биш байх тул тухайн саналыг хүлээж авах боломжгүй байна. Мөн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал-2010”-ын Мэдээллийн аюулгүй байдлын тухай заалтын Үзэл баримтлалын 3.4.1.2-т: “Монгол Улсын нутаг дэвсгэрийн орон зайн мэдээллийн нэгдсэн санг байгуулж, үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орныг хөгжүүлэхэд ашиглана” гэж туссан байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж боловсруулсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс “геологийн судалгаа хийх,” гэснийг хасаж газрын хэвлийг хөндөхгүйгээр гадаргуугийн геологийн суурь судалгааны ажил гүйцэтгэх боломж нээгдэнэ.

8.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурал 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан. Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина” гэж заасан. Хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын баяжуулах үйлдвэр, дулааны станц, айл өрхөд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулах боломжгүй болсон.

Дээрх асуудлыг шийдэх хүрээнд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд уул уурхайн бүтээгдэхүүнийг баяжуулж, боловсруулж, нэмүү өртөг шингээн экспортлох үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжих, арилжааний үнийг ам нөхцөлөөр байхаар тусгасан.

9.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээний асуудлыг тусгасан. Мөн Зөвшөөрлийн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр,

11 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлээр баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дэмжигдсэн. Энэхүү хүрээнд дээрх геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд нэмэлт оруулахаар хуулийн төсөлд тусгасан.

10.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар газрын ховор элементийн эрэл, хайгуул, ашиглалтын асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулах боломжтой болно.

---ooOoo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.32 – 4.1.44 дэх заалт:

4.1.32. “чухал ашигт малтмал” гэж олон улсын өндөр технологид ашиглагддаг, эрэлт, хэрэгцээ өндөртэй, эдийн засгийн ач холбогдол бүхий ашигт малтмалыг;

4.1.33. “эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах эрдэс, элемент” гэж химийн нэгдлийн хувьд үндсэн ашигт малтмалтай хамт үүсэж хуримтлагдсан, технологийн боловсруулалтаар ялган авах боломжтой, эдийн засгийн үр ашигтай эрдэс, химийн элементийг;

4.1.34. “баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу төрөөс олгосон баяжуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд олгох эрхийг;

4.1.35. “баяжуулалтын үйл ажиллагаа” гэж ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ордын чулуулгаас ашигт эрдсийг ялган авах, чанарыг сайжруулах үйлдвэрлэл, технологийн цогц үйл ажиллагааг;

4.1.36. “уурхай болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл” гэж уул уурхайн төслийг хэрэгжүүлэх техник, технологийн шийдэл, эдийн засгийн үр ашиг болон бусад холбогдох хүчин зүйлсийг иж бүрэн тооцсон ашигт малтмалын орд, эсхүл түүний хэсгийг ашиглах, баяжуулалтын үйл ажиллагааг тусгасан баримт бичгийг;

4.1.37. “уурхай болон баяжуулах үйлдвэрийн зураг төсөл” гэж уурхайн болон баяжуулах үйлдвэрийн технологийн байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, дэд бүтцийн шийдэл, үйл ажиллагааны төлөвлөлтийг иж бүрэн, нарийвчлан тооцсон баримт бичгийг;

4.1.38. “маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардлагатай хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэх эрхийг хуулийн этгээдэд олгосон зөвшөөрлийг;

4.1.39. “геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ” гэж геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээг;

4.1.40. “гэрээт талбай” гэж энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээгээр түр хугацаанд тодорхойлсон, геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэхээр тогтоосон талбайг;

4.1.41. “хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх эрх” гэж энэ хуулийн 4.1.40-д заасан талбайгаас сонгосон хэсэгт хайгуулын тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлт гаргах эрхийг;

4.1.42.“төсөл хэрэгжүүлэгч” гэж геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг;

4.1.43.“төсөл боловсруулагч” гэж уул уурхайн эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төсөл боловсруулах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, эсхүл Монгол Улсын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан зөвлөх инженер бүхий хуулийн этгээдийг;

4.1.44.“хувийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн суурь судалгаа, эрлийн ажил” гэж том, дунд масштабын геологийн зураглал, геофизик, геохими болон бусад төрлийн судалгааны арга, аргачлал, заавар, шаардлагыг хангасан төслийн хүрээнд гэрээт талбайд гүйцэтгэх ажлыг.”

2/9 дүгээр зүйлийн 9.1.18, 9.1.19, 9.1.20 дахь заалт:

“9.1.18.чухал ашигт малтмалын төрөл, чиглэл тус бүрээр бодлого, стратеги, замын зураг боловсруулах, хэрэгжүүлэх;

9.1.19.чухал ашигт малтмалын жагсаалтыг батлах;

9.1.20.уурхай болон баяжуулах үйлдвэрийн зураг төсөл зохиогчид хяналт тавих дүрэм батлах.”

3/15¹ дугаар зүйл:

“15¹ дугаар зүйл.Геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах

15¹.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл олгогдоогүй, ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, сонгон шалгаруулалтын талбайд хамрагдаагүй, эсхүл сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй талбайд геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хүсэлтийг геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

15¹.2.Энэ хуулийн 15¹.1-д заасан хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

15¹.2.1.хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн мэдээлэл, хаяг, холбоо барих мэдээлэл;

15¹.2.2.Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай тодорхойлолт;

15¹.2.3.гэрээ байгуулах талбайн солбицол, байршлын зураг, хэмжээ;

15¹.2.4.гүйцэтгэх ажлын үе шат, төрөл, хэмжээ, хугацаа, өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, техникийн болон мэргэжлийн чадавхыг тусгасан ажлын төсөл;

15¹.2.5.байгаль орчныг хамгаалах, газрын эвдрэл, нөхөн сэргээлтийн арга хэмжээг тусгасан төлөвлөгөө;

15¹.2.6.үйлчилгээний хөлс төлсөн баримт.

15¹.3.Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15¹.1-д заасан хүсэлтийг хүлээн авч бүртгэн, ажлын 20 өдөрт багтаан дараах асуудлыг шалгаж шийдвэрлэнэ:

15¹.3.1.хүсэлт, хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;

15¹.3.2.энэ хуулийн 15¹.2.4-т заасан төслийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг батлах эсэх талаар дүгнэлт гаргуулах;

15¹.4.Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15¹.3.2-т заасан дүгнэлтийг үндэслэн тухайн хуулийн этгээдийн төслийг батална.

15¹.5.Шаардлага хангасан хуулийн этгээдтэй геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээг 2 хүртэл жилийн хугацаатай байгуулна.

15¹.6.Энэ хуулийн 4.1.39-д заасан гэрээ байгуулсан тохиолдолд тухайн талбайд уг гэрээний хугацаанд бусад этгээдэд тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

15¹.7.Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан этгээд дараах үүрэг хүлээнэ.

15¹.7.1.батлагдсан ажлын төслийн хүрээнд геологийн судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх;

15¹.7.2.гэрээт талбайгаас ашигт малтмал олборлох болон борлуулахгүй байх;

15¹.7.3.гэрээгээр үүссэн эрхийг бусдад шилжүүлэх, барьцаалах, ашиглуулахгүй байх;

15¹.7.4.гэрээний явцад бий болсон анхдагч материал, тайлан, сорьц, дээж, зураглал, тоон мэдээллийг үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд шилжүүлэх;

15¹.7.5.жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайлан, ажлын үр дүнгийн эцсийн тайланг гэрээнд заасан хугацаанд геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

15¹.7.6.хэтийн төлөвгүй талбайг үе шаттайгаар буцаан чөлөөлөх;

15¹.7.7.хэтийн төлөв бүхий хэсгийг энэ хуульд нийцүүлэн ялган тогтоож, үлдэх талбайг буцаан чөлөөлөх;

15¹.7.8.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үүргийг биелүүлэх.

15¹.8.Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15¹.5-д заасан гэрээг өөрийн цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.

15¹.9.Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хувийн хөрөнгөөр геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх боломжтой энэ хуулийн 15¹.1-д заасан талбайн мэдээллийг ил тод, нээлттэй хэлбэрээр тогтмол мэдээлнэ.”

15¹.10.Хувийн хөрөнгөөр геологийн суурь судалгаа, эрлийн ажил гэрээгээр гүйцэтгэх нэг талбайн хэмжээ 35 мянган гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байна.”

4/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

“18.3.Энэ хуулийн 18.1-д заасан баримт бичгийг хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим хэлбэрээр ирүүлнэ.”

5/19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр зүйл.Геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээний дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох

19¹.1.Энэ хуулийн 4.1.39-д заасан геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд гэрээт талбайгаас сонгосон хэсэгт гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

19¹.2.Энэ хуулийн 19¹.1-д заасан хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

19¹.2.1.гэрээний хэрэгжилтийн тайлан;

19¹.2.2.ажлын үр дүнгийн эцсийн тайлан, анхдагч материал, зураг, тайлбар, сорьц, дээж хүлээлгэн өгсөн баримт;

19¹.2.3.хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн солбицол, хэмжээ, зураг;

19¹.2.4.үйлчилгээний хөлс төлсөн баримт.

19¹.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19¹.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор дараах асуудлыг шалгаж шийдвэрлэнэ:

19¹.3.1.гэрээний үндсэн үүргийг бүрэн биелүүлсэн эсэх;

19¹.3.2.хүсэлтэд дурдсан талбай нь энэ хуульд заасан хэмжээ, хэлбэр, давхцал, хязгаарлалтын шаардлагыг хангаж байгаа эсэх;

19¹.3.3.мэдээлэл, тайлан, анхдагч материалыг үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд хүлээлгэн өгсөн эсэх.

19¹.4.Энэ хуулийн 19¹.3-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

19¹.5.Энэ хуулийн 19¹.4-т заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ нь гэрээт талбайн 20 хувиас ихгүй байна.

19¹.6.Хүсэлт гаргасан этгээд энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд эхний жилийн төлбөрийг төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдрийн дотор хайгуулын тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

19¹.7.Энэ хуулийн 19¹.6-д заасны дагуу олгосон тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар 1 удаа сунгаж болно.

19¹.8.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, татварын албанд мэдэгдэж, нийтэд ил тод мэдээлнэ.”

6/20 дугаар зүйлийн 20.5.7 дахь заалт:

“20.5.7.гэрээ байгуулсан этгээд нь энэ хуулийн 15¹.7.5-д заасан эцсийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор хүсэлт гаргасан тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрлийг олгоно.”

7/20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нь нэг гектар тутамд 7 нэгж байна.”

8/21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалт:

“21.1.9.тухайн жилд гүйцэтгэсэн ажлын мэдээллийг төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлэх.”

9/27 дугаар зүйлийн 27.1.15, 27.1.16 дахь заалт:

“27.1.15.уурхай, баяжуулах үйлдвэрийг нээхээс өмнө нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөөг боловсруулж, 3-5 жил тутам тодотгон, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт гаргуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх ба уурхай, баяжуулах үйлдвэрийг хаахаас 3-аас доошгүй жилийн өмнө төлөвлөгөөний сүүлийн тодотголыг хийх.

27.1.16.уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах хяналт-шинжилгээнд шаардагдах хөрөнгийг олон улсад нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгслээр баталгаажуулах, эсхүл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тусгай дансанд доор дурдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх.

Ашиглалтын жил	Жил бүр бүрдүүлэх хаалтын санхүүжилт (хувиар)																	
	Олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах техник, эдийн засгийн үндэслэлд заасан нийт хугацаа (жилээр)																	
	1-3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
1	100	50	35	25	20	18	16	15	14	12	12	12	10	10	10	10	8	8
2	-	50	35	25	20	18	16	15	14	12	12	11	10	10	9	9	8	8
3	-	-	30	25	20	18	16	15	14	12	12	11	10	10	9	9	8	8
4	-	-	-	25	20	18	16	15	14	12	12	11	10	10	9	9	8	8
5	-	-	-	-	20	18	16	15	14	12	12	11	10	10	9	9	8	8
6	-	-	-	-	-	10	16	15	14	12	12	11	10	10	9	9	8	8
7	-	-	-	-	-	-	4	10	14	12	12	11	10	10	9	9	8	8
8	-	-	-	-	-	-	-	-	2	12	12	11	10	10	9	9	8	8
9	-	-	-	-	-	-	-	-	-	4	4	11	10	10	9	9	8	8
10	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	10	10	9	9	8	8	
11	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	9	9	8	8	
12	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	8	8	
13	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	4	4

Тайлбар: Хаалтын санхүүжилтийн баталгааны тухайн жилд байршуулах хувь хэмжээг шугаман аргаар тооцно. Уурхай, баяжуулах үйлдвэрийн ашиглалтын нийт хугацааны гуравны хоёрт багтаан бүрэн байршуулсан байна. Гурав хүртэл жилийн хугацаанд ашиглах уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалтын санхүүжилтийн баталгааг эхний жилд бүрэн байршуулна.”

10/ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ:

“ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТ

28¹ дугаар зүйл.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах шаардлага

28¹.1.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

28¹.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд энэ хуулийн 28¹.1 дэх хэсэг хамаарахгүй.

28¹.3.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана.

28¹.4.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

28¹.4.1.технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийсэн байх;

28¹.4.2.газар ашиглах эрхийн гэрчилгээтэй байх;

28¹.4.3.баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд энэ хуулийн 48.4-т заасан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг гаргуулсан байх;

28¹.4.4.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан байх;

28¹.4.5.ус хангамжийн баталгаат эх үүсвэрийг тогтоож, дүгнэлт гаргуулсан байх.

28¹.5.Энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

28² дугаар зүйл.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

28².1.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх эдэлнэ:

28².1.1.баяжмал, бүтээгдэхүүнээ худалдах;

28².1.2.тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах;

28².1.3. зохих татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;

28².1.4.энэ хуульд заасан бусад.

28².2.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

28².2.1.үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд жил бүр тогтмол мэдээлэх;

28².2.2.химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зохих журмын дагуу саармагжуулах, устгах;

28².2.3.баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмж, технологи өөрчлөгдсөн тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх;

28².2.4.энэ хуульд заасан бусад.

28².3.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, эдийн засгийн үндэслэл болон тусгай зөвшөөрөлд тэмдэглэснээс бусад төрлийн ашигт малтмал, эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмал баяжуулах, борлуулахыг хориглоно.

28².4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлагыг хангаж ажиллана.”

28³ дугаар зүйл.Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх

28³.1.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл авснаас хойш 90 хоногийн дотор техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан технологийн дагуу үйлдвэр барьж байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 48.6.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

28³.2.Энэ хуулийн 28³.1-д заасан төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай барилга байгууламжийг барьж байгуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, турших, тохируулах ажлыг гүйцэтгэн, хэвийн үйл ажиллагаанд бэлтгэнэ.

28³.3.Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь чанарын хувьд Монгол Улсын стандартад нийцсэн байна.

28³.4.Энэ хуулийн 28³.4-т заасан бүтээгдэхүүний чанарыг Монгол Улсад, эсхүл гадаад улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр тодорхойлно.”

29¹ дүгээр зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах шаардлага

29¹.1.Ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн олборлож байгаа эсэхэд хяналт тавих, нөөцийн хөдөлгөөн, төлөв байдлыг тодорхойлох, уурхайн бүтээн байгуулалтын бүх үе шатны төлөвлөлтөд хяналт тавих, уурхайн хажуу болон хаягдал чулуулгийн овоолгын чулуулгийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

29¹.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан байна:

29¹.2.1.маркшейдерийн мэргэжлээр бакалавраас доошгүй зэрэгтэй байх;

29¹.2.2.маркшейдерийн мэргэжлээр 8-аас доошгүй жилийн хугацаанд ил болон далд уурхайд ажилласан туршлагатай байх;

29¹.2.3.ял шийтгэлгүй байх;

29¹.3.Энэ хуулийн 29¹.2-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

29² дугаар зүйл.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа

29².1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

29².1.1.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолгын хэмжээ, уулын ажилд хамрагдсан талбай, ил болон далд уурхайн төлөвлөлт, гүйцэтгэлд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

29².1.2.ашигт малтмалын ордын нөөцийг хэрхэн ашиглаж байгаа эсэх талаар санал дүгнэлт гаргах;

29².1.3.энэ хуулийн 29¹.1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно;

29².1.4.энэ хуулийн 29².1.1-д заасан хөндлөнгийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг хариуцах;

29².1.5.энэ хуулийн 29¹.1.1-д заасан үйл ажиллагааг хөндлөнгийн хараат бусаар хэрэгжүүлэх.

29².2.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах зааврыг төрийн захиргааны төв байгууллага батална.”

11/32 дугаар зүйлийн 32.4, 32.5 дахь хэсэг:

“32.4.Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

32.5.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг Үндэсний статистикийн хорооноос зарласан хэрэглээний үнийн индексийн өмнөх жилийн өсөлтийн хувиар индексжүүлэн тооцно.”

12/35 дугаар зүйлийн 35.13, 35.14 дэх хэсэг:

“35.13.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уурхай, баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсний дараа геологи, уул уурхайн асуудал болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын хамтарсан ажлын хэсэгт хүлээлгэн өгч дүгнэлт гаргуулснаар энэ хуулийн 27.1.16-д зааснаар төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүснэ.”

13/42¹ дүгээр зүйл:

“42¹ дүгээр зүйл.Орон нутгийн оролцоо

42¹.1.Хайгуул, ашиглалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаж, тогтмол мэдээлж, тайлагнана.

42¹.2.Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно:

42¹.2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгт оролцох, санал, зөвлөмж өгөх;

42¹.2.2.салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх;

42¹.2.3.салбарын хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр шилдэг туршлага, инновацыг нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;

42¹.2.4.холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;

42¹.2.5.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдээлэх, гомдол гаргах.”

14/47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалт, 47.20, 47.21 дэх хэсэг:

“47.1.4.бичил уурхай эрхлэгч;

47.20.Үндсэн ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах, эдийн засгийн ач холбогдолгүй, тодорхой хэмжээний эрдэс, металлд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахгүй байж болох бөгөөд тус хэмжээг ашигт малтмалын бүтээгдэхүүний төрөл, түүнд агуулагдах эрдэс, металлын хэмжээг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

47.21.Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын гэрээг гааль, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны байгууллагын нэгдсэн бүртгэлд бүртгэж, хяналт тавина.”

15/48 дугаар зүйлийн 48.6.4 дэх заалт, 48.15 дахь хэсэг:

“48.6.4.тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагааны тайлан, эсхүл үйл ажиллагаа явуулаагүй талаарх мэдэгдлийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

48.15.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон тайланг жил бүр батлагдсан маягтын дагуу гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор, аймаг, нийслэлийн Засаг дарга уг тайланг нэгтгэн геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.”

16/64¹ дүгээр зүйл:

“64¹ дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд халдахыг хориглох

64¹.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуульд заасан эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглоно.

64¹.2.Геологи, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаанд хууль бусаар халдах, тоног төхөөрөмжийг эвдэх, тээвэрлэлт, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулах, уурхайн гарцыг хаах, цахилгаан, усан хангамжийг зориудаар таслахыг хориглоно.

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “гэж” гэсний дараа “газрын ховор элементүүдээс бусад” гэж, 5 дугаар зүйлийн 5.3, 5.4, 5.5 дахь хэсгийн “ашигт малтмалын нөөц ашигласны” гэсний дараа “тусгай” гэж, 16 дугаар зүйл, мөн зүйлийн 16.1, 16.4, 16.5, 16.6 дахь хэсгийн “геологийн” гэсний дараа “суурь” гэж, 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн “Ашиглалтын” гэсний дараа “болон баяжуулалтын” гэж, 48 дугаар зүйлийн 48.6.2

дахь заалтын “уулын ажлын” гэсний дараа “болон баяжуулах үйлдвэрийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

“7.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын болон маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.”

2/11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.25 дахь заалт:

“11.1.19.түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалт болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох.

11.1.25.энэ хуулийн дагуу гэрээгээр болон сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах.”

3/18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт:

“18.1.1.тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, цахим шуудангийн хаягийг тусгасан албан ёсны тодорхойлолт;”

4/32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг:

“32.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь гектар тутамд эхний жилд 3.5 нэгж, 2-3 дахь жилд тус бүр 10.5 нэгж, 4-6 дахь жилд тус бүр 35 нэгж байна.

32.2.Энэ хуулийн 19¹.5-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр нь гектар тутамд эхний жилд 10.5 нэгж, 2-4 дэх жилд 35 нэгж байна.

32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь талбайн гектар тутамд жил бүр нүүрс, шохойн чулууны хувьд 12 нэгж, бусад ашигт малтмалын хувьд 48 нэгж байна.”

5/33 дугаар зүйлийн 33.1.1 – 33.1.5 дахь заалт:

“33.1.1.тусгай зөвшөөрлийн 2 дахь жилд 16 нэгж.

33.1.2.тусгай зөвшөөрлийн 3 дахь жилд 30 нэгж.

33.1.3.тусгай зөвшөөрлийн 4 дэх жилд 44 нэгж.

33.1.4.тусгай зөвшөөрлийн 5 дахь жилд 56 нэгж.

33.1.5.тусгай зөвшөөрлийн 6 дахь жилд 70 нэгж.”

6/35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг:

“35.4.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авсны дараа ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, баяжуулах үйлдвэрийг ажиллуулж эхэлнэ.”

7/42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

“42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, баяжуулах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах

гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, уг гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.”

8/47 дугаар зүйлийн 47.3.1 дэх заалт:

“47.3.1.олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодын эрчим хүч болон дулааны хэрэглээний зориулалтаар худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь;”

9/47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 1 дэх мөр:

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар	0-5000 хүртэл	0.00	0.00	0.0
				5000-6000 хүртэл	11.0	1.0	0.5
				6000-7000 хүртэл	12.0	2.0	1.0
				7000-8000 хүртэл	13.0	3.0	1.5
				8000-9000 хүртэл	14.0	4.0	2.0
				9000 ба түүнээс дээш	15.0	5.0	2.5

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний” гэснийг “засагт нөлөөлөхүйц,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.26” гэснийг “11.1.29” гэж, 16 дугаар зүйл, мөн зүйлийн 16.1, 16.3, 16.4, 16.6 дахь хэсгийн “төсвийн” гэснийг “төсөв болон бусад эх үүсвэрийн” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “төрийн мэдээллийн” гэснийг “үндэсний геологи, эрдэс баялгийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “Энэ хуулийн 17.4-т заасны дагуу ялгасан” гэснийг “Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ болон сонгон шалгаруулалт зарлах” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрх эдэлнэ” гэснийг “эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж, мөн зүйлийн 21.1.5 дахь заалтын “3 удаа” гэснийг “1 удаа” гэж, 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн “мэдээлнэ.” гэснийг “мэдэгдэнэ.” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “Хайгуулын болон ашиглалтын” гэснийг “Хайгуул, ашиглалт болон баяжуулалтын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “, 20”, “болон орон нутгийн” гэснийг, 4.1.23 дахь заалтын “Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн,” гэснийг, 17 дугаар зүйлийн гарчгийн “сонгон шалгаруулалтын” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.7 дахь хэсгийн “болон үүсмэл орд ашиглах” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.8 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.20 дахь заалт, 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 47³ дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.13,

48.14 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрдэнэтийн-Овоо зэс, молибдений ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамааран үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувийг доор дурдсанаар ногдуулсугай:

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар	0-5000 хүртэл	0.0	0.0	0.0
				5000-6000 хүртэл	22.0	11.0	0.5
				6000-7000 хүртэл	24.0	12.0	1.0
				7000-8000 хүртэл	26.0	13.0	1.5
				8000-9000 хүртэл	28.0	14.0	2.0
				9000 ба түүнээс дээш	30.0	15.0	2.5

2 дугаар зүйл.2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5-д заасны дагуу сунгана.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг хайгуулын тусгай зөвшөөрлийн 4-6 дахь жилийн төлбөрийн хэмжээтэй адил хэмжээгээр жил бүр төлнө.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн талбайн гектар тутамд Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-33.1.5-д зааснаас багагүй хэмжээний зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр гүйцэтгэнэ.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсэг:

“10.5.Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэр нь уул уурхайн бүтээгдэхүүнийг энэ хуулийн 10.2-т заасан этгээдээс биржээр дамжуулан баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж, экспортлох зорилгоор арилжиж болно.”

2 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “экспортлоход” гэснийг хассугай:

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ... - ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.2-т заасан” гэсний дараа “газрын ховор элементүүдээс бусад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийн гарчиг, 11¹.1 дэх хэсэг, 12.1 дэх хэсэг, 14.1 дэх хэсэг, 28.2.6 дахь заалт, 28.2.7 дахь заалт, 28.2.8 дахь заалт, 32.2 дахь хэсэг, 34.7 дахь хэсэг, 36.1.5 дахь заалт, 43.4 дэх хэсэг, 48.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэснийг “байгаль орчны төлөв байдлын үнэлгээ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “газрын ховор элемент агуулсан бодисыг” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтын “газрын ховор элемент” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8.31, 8.32 дахь заалт тус тус нэмсүгэй.

8.31.Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх	Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
8.32.Маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.20, 8.21, 8.22, 8.23 дахь заалтын “боловсролын” гэснийг “цөмийн энергийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.29, 8.30 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.13, 25.1.14 дэх заалтыг нэмсүгэй.

“25.1.13.геологийн суурь судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах үйлчилгээний хураамж 1 000 000 төгрөг.

25.1.14.баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн төлбөр нь жил бүр 10 000 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “геологийн судалгаа хийх,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй.

1/59 дүгээр зүйлийн 59.2.2.4 дэх дэд заалт:

“59.2.2.4.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын хэмжээ.”

2/59 дүгээр зүйлийн 59.10 дахь зүйл, 59.10.1, 59.10.2 дахь заалт, 59.11 дэх зүйл:

“59.10.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 59.7, 59.2.2.4-т заасны дагуу тухайн жилийн төсвийн саналын хамт аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр жилийн төлөвлөгөөг боловсруулж, дараах мэдээллийн хамт санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

59.10.1.аж ахуйн нэгж тус бүрийн тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын олборлолт явуулж байгаа талбайн байршил, хэмжээ, олборлолтын хэмжээ болон холбогдох бусад мэдээлэл;

59.10.2.аж ахуйн нэгжийн ашигт малтмалын олборлолт явуулж байгаа талбай нь хоёр болон түүнээс дээш аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрийг дамнан байрлаж байгаа тохиолдолд тухайн аймаг, сум, дүүрэг бүрд хамаарах талбайн хэмжээ, олборлолтын хэмжээ болон олборлосон ашигт малтмалаас худалдсан хэмжээг тусгасан мэдээлэл.

59.11.Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 59.10-т заасны дагуу сар бүрийн төлөвлөгөө гүйцэтгэл болон холбогдох мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтын “47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10” гэснийг “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 15” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсгийг “Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 15 хувийг тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд тэнцүү хэмжээгээр, 30 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймаг, нийслэлд бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж, мөн хуулийн 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тухайн эх үүсвэрийн 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймаг, улсын зэрэглэлтэй хотод тэнцүү хэмжээгээр тус тус хуваарилна.” гэж өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн “Улсын геологийн сан” гэснийг “Үндэсний геологийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн “, мэдээллийн байгууллага” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “ашигт малтмал” гэсний дараа “болон нуурын давсны” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

“2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “их хэмжээний хохирол” гэж Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1 дэх заалтад заасныг ойлгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “10.26,” гэсний дараа “10.27,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.16 дахь заалтын “10.27 дугаар зүйл” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ